




ДАМЖУУЛАХ Сүлжээ



ЦДҮС ТӨХК-ИЙН ХЭВЛЭЛ
www.transco.mn

2005 оноос эрхлэн гаргав.

№01 (145) 2020 оны 01 сар

ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛИАР ШАГНАГДЛАА

2020 оноо угтах шинэ оны босгон дээр эрчим хүчний салбарт оруулсан хувь нэмэр, ажил хөдөлмөрөө үнэлүүлж Монгол Улсын ерөнхийлөгчийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 227 дугаар зарлигаар Төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт” медалиар Хангайн бүсийн салбарын ашиглалтын инженер Д.Золзаяа,

Зүүн-Өмнөд бүсийн салбарын ХАБЭА-н инженер Д.Анхбаяр, ээлжийн техникч И.Оюунцэцэг, ээлжийн инженер Т.Ганболд нар шагнагдаж, энгэрээ мялаалаа.

Захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Т.Аюуш



Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдсан ЗӨБС-ын ээлжийн техникч И.Оюунцэцэг ЭХЗХ-ны зохицуулагч Э.Түвшинчулууны хамт

НҮҮР-2

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН 2019 ОНЫ ШИЛДЭГ АЖИЛ

НҮҮР-3

ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА-УУД

НҮҮР-3

САЛБАРЫН 2019 ОНЫ "ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН"- УУД ТОДОРЛОО

НҮҮР-9

ЗАСВАРЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭВ

НҮҮР-9

2019 ОНЫ »ШИЛДЭГ ДЭД СТАНЦ«-ЫГ ШАЛГАРУУЛАВ

НҮҮР-10

ЧАДАМЖИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОВ

НҮҮР-11

ХАБЭА, ХЯНАЛТЫН ИНЖЕНЕРИЙН VI ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАВ

НҮҮР-11

ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАВ



Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдсан ЗӨБС-ын ээлжийн инженер Д.Ганболд салбарынхаа хамт олонтойгоо




Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдсан ЗӨБС-ын ХАБЭАИ Д.Анхбаяр компанийн удирдлагуудын хамт

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 2019 ОНЫ "ШИЛДЭГ ИНЖЕНЕР"-ЭЭР ШАЛГАРАВ

Монгол Улсын гал голомт болсон эрчим хүчний салбар 2019 оны ажлаа дүгнэж, шилдгүүдээ тодруулсанаас манай компанийн Улаанбаатар салбарын Диспетчерийн албаны дарга З.Өлзийбаяр “Шилдэг инженер”-ээр шалгарч, эрчим хүчний салбарын мэргэжил нэгт шилдэг инженерүүдээс хийсэн бүтээсэн ажлаараа манлайллаа.

Захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Т.Аюуш





ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН 2019 ОНЫ

“ШИЛДЭГ АЖИЛ”

1.

220/110 кВ-ын Ил хуваарилах байгууламж-4 дээр автотрансформатор-1, 2-ыг зэрэгцээ ажиллагаанд оруулж, Монгол Улсын эрчим хүчний системийн эх үүсвэрийн найдвартай ажиллагааг нэмэгдүүлэв.



6.

Монгол Улсын Зүүн-Өмнөд бүсэд нар салхины эх үүсвэрүүд шинээр ашиглалтад орсонтой холбогдуулан 207, Айраг, Сайншанд, Замын-Үүд цахилгаан дамжуулах агаарын шугамуудад өндөр давтамжийн хоригтой үндсэн хамгаалалт, өндөр үелзлэлийн постыг төхөөрөмжүүдийн хамт шинээр суурилуулан ашиглалтад оруулав. Ингэснээр сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс нийлүүлэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний чадлын урсгалын найдвартай ажиллагааг нэмэгдүүлэв.



2.

Монгол Улсын эрчим хүчний салбарт анх удаа 200 МВА хүчин чадалтай автотрансформаторын засварын ажлыг Украин улсын мэргэжилтнүүдтэй хамтран гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өгөхөд бэлэн болов.



7.

Алтай-Улиастайн эрчим хүчний системийг 110 кВ-ын хүчдэлийн түвшинд шилжүүлэн Төвийн эрчим хүчний системтэй зэрэгцээ ажиллагаанд оруулах техникийн боломжийг бүрдүүлэв.



3.

Нийслэлийн агаар орчны бохирдлыг бууруулах, гэр хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах ажлын хүрээнд Хүчит шонхор дэд станцыг шинээр барьж, 107, 108, 109, 110 дугаар цахилгаан дамжуулах агаарын шугамын дамжуулах удсыг сольж, агаарын шугамын дамжуулах чадварыг сайжруулсан, утаагүй шахмал түлшний үйлдвэрийг цахилгаанаар хангах зориулалттай, 110/10 кВ-ын 2x25 мВА-ийн хүчин чадал бүхий ПРП-110 дэд станцын өргөтгөлийн ажлыг гүйцэтгэж, тус тус ашиглалтад оруулснаар нийслэл хотын агаарын бохирдлыг бууруулахад жинтэй хувь нэмэр оруулав.



8.

Олон жилийн хугацаанд шийдвэрлэж чадахгүй байсан 205, 206, 208, Үйлдвэр-110 өндөр хүчдэлийн шугамын хамгаалалтын зурвасын нягтрал ихтэй хэсгийг бүрэн чөлөөлж, хаалт, хашилт, анхааруулах санамж байрлуулан, ард иргэд, олон нийтэд бүх төрлийн мэдээллийн хэрэгслээр зөвлөгөө, сурталчилгаа явуулав. Ингэснээр эрчим хүчний шугам сүлжээний аюулгүй байдлыг сайжруулж, эрчим хүчний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллав.



4.

Оюутолгойн уурхайг төвийн эрчим хүчний системээс цахилгаан эрчим хүчээр хангах дамжуулах сүлжээний дэд бүтцийг барьж байгуулах ажлын хүрээнд 220/110/35 кВ-ын Мандал дэд станцыг шинээр барьж, Чойр-Мандалговийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг 220 кВ-ын хүчдэлийн түвшинд шилжүүлсэнээр өмнийн говийн цахилгаан эрчим хүчний найдвартай ажиллагааг сайжруулав.



9.

Говийн бүсийн салбарын оффисийн барилга, компанийн агуулахын барилга, Улаанбаатар салбарт 8 автомашины гараж тус тус шинээр барьж, ажилтнуудынхаа ажиллах нөхцөлийг сайжруулав.



5.

Ачаалал өндөртэй дэд станцуудын схем, горим ажиллагааг сайжруулах зорилгоор Мандалговь, Баясгалант, Зүүнхараа, Бугант, Улаанхуаран, Баянхонгор, Мөрөн зэрэг дэд станцын хүчний трансформаторуудын суурилагдсан чадлыг 44 мВА-аар нэмэгдүүлснээр хэрэглэгчдийн цахилгаан хангамжийн тогтвортой ажиллагааг хангав.



10.

Монгол Улсад эрчим хүчний салбар үүсч хөгжсөний 97 жилийн ойг угтсан “Спортын их наадам-2019” тэмцээнд амжилттай оролцож, гар бөмбөгийн төрөлд эрэгтэй, эмэгтэй баг алтан медаль, сагсан бөмбөгийн төрөлд эмэгтэй баг хүрэл медаль, шатрын төрөлд эмэгтэй баг алтан медаль, ширээний теннисний төрөлд эрэгтэй баг мөнгөн медаль тус тус хүртэж, багийн нийт дүнгээр эрчим хүчний салбарын үйлдвэр компаниудаа тэргүүлэн, “Үнэмлэхүй аварга баг”-аар шалгарч цомын эзэн болов.





2019 ОНЫ "ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА"-УУД

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2019 оны Хөдөлмөрийн аварга удирдах ажилтан"-аар Төвийн бүсийн салбарын ерөнхий инженер М.Чулуунбаатар, "Хөдөлмөрийн аварга инженер техникийн ажилтан"-аар Улаанбаатар салбарын Реле хамгаалалт автоматик, хэмжилт, туршилтын албаны

ахлах бөгөөд реле хамгаалалт автоматикийн инженер Д.Өлзийсайхан, "Хөдөлмөрийн аварга шуурхай ажиллагааны инженер техникийн ажилтан"-аар Зүүн-Өмнөд бүсийн салбарын ээлжийн инженер Т.Ганболд, "Хөдөлмөрийн аварга ашиглалтын монтёр"-оор Говийн бүсийн салбарын ээлжийн монтёр Н.Батням, "Хөдөлмөрийн аварга

засварын монтёр"-оор Хангайн бүсийн салбарын шугамын засварын монтёр Х.Сундуй, "Хөдөлмөрийн аварга албан хаагч"-аар Захиргаа удирдлагын хэлтсийн ахлах бөгөөд хүний нөөцийн мэргэжилтэн Б.Цацрал, "Хөдөлмөрийн аварга ажилтан"-аар Нийтлэг үйлчилгээ, тээвэр механизмын хэлтсийн жолооч Б.Бат-Оргил нар шалгарлаа.

Компанийн эрхэм зорилгыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулж, эрхэлсэн ажилдаа амжилт гарган хамт олноо манлайлан ажилласан 2019 оны "Хөдөлмөрийн аварга"-ууддаа ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.

Захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Т.Аюуш



"Хөдөлмөрийн аварга" (Удирдах ажилтан) Төвийн бүсийн салбарын ерөнхий инженер М.Чулуунбаатар



"Хөдөлмөрийн аварга" (ИТА) Улаанбаатар салбарын Реле хамгаалалт автоматик, хэмжилт, туршилтын албаны ахлах бөгөөд реле хамгаалалт автоматикийн инженер Д.Өлзийсайхан



"Хөдөлмөрийн аварга" (ША-ны ИТА) Зүүн-Өмнөд бүсийн салбарын ээлжийн инженер Т.Ганболд



"Хөдөлмөрийн аварга" (Ашиглалтын монтёр) Говийн бүсийн салбарын ээлжийн монтёр Н.Батням



"Хөдөлмөрийн аварга" (Засварын монтёр) Хангайн бүсийн салбарын шугамын засварын монтёр Х.Сундуй



Хөдөлмөрийн аварга" (Албан хаагч) Захиргаа удирдлагын хэлтсийн ахлах бөгөөд хүний нөөцийн мэргэжилтэн Б.Цацрал



"Хөдөлмөрийн аварга" (Ажилтан) Нийтлэг үйлчилгээ, тээвэр механизмын хэлтсийн жолооч Б.Бат-Оргил

САЛБАРЫН 2019 ОНЫ "ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН"- УУД ТОДОРЛОО



ЗӨБС-ын 2019 оны "Тэргүүний ажилтан" өндөр үелзлэлийн холбооны инженер Ц.Энхжаргал



ТБС-ын 2019 оны "Тэргүүний ажилтан" шугамын засварын монтёр С.Батмөнх



ХБС-ын 2019 оны "Тэргүүний ажилтан" сантехникч М.Батсайхан ХБС-ын "Шилдэг залуу ажилтан"-аар шалгарсан компьютерийн инженер Э.Батням, компанийн "Хөдөлмөрийн аварга"-аар шалгарсан шугамын засварын монтёр Х.Сундуй нарын хамт




Төв удирдлагын 2019 оны "Тэргүүний ажилтан" Санхүү, эдийн засгийн хэлтсийн мөнгөн хөрөнгийн нягтлан бодогч Э.Болор-Эрдэнэ



ГБС-ын 2019 оны "Тэргүүний ажилтан" тооцооны нягтлан бодогч Т.Оюунбилэг



Улаанбаатар салбарын 2019 оны "Тэргүүний ажилтан" дэд станцын засварын монтёр Р.Батдорж




УЛААНБААТАР САЛБАР

◀ АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ▶

220/110 кВ-ын ИХБ-4-ийн АТ-1, 2-ыг зэрэгцээ ажиллагаанд залгаж дамжуулах чадварыг 125 МВТ чадлаар нэмэгдүүлэх ажлыг богино хугацаанд амжилттай хийж гүйцэтгэсэн. 2010 онд АТ-2-ыг ажилд залгасан ч зэрэгцээ ажиллагаанд залгаж чадалгүй 9 жилийн хугацаа өнгөрсөн. Энэ ажилд инженерийн шийдэл гаргаж, горим тооцоо хийж, маш богино хугацаанд тоноглолын угсралт хийж, реле хамгаалалтыг шинээр монтажлан тусдаа таслууртай, реле хамгаалалттай болгосон нь Эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг хангасан томоохон ажил болсон. АТ-1, 2-ыг зэрэгцээ ажиллагаанд залгах ажлыг өвлийн их ачааллаас өмнө хөдөлмөр хамгааллын зөрчилгүй, богино хугацаанд хурдан шуурхай, найдвартайгаар Улаанбаатар салбарын ажилтнууд амжилттай хийж гүйцэтгэсэн.



Монгол Улсад анх удаа 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын схем холболтоос шалтгаалан 2, 3, 4 төгсгөлт хамгаалалтыг амжилттай нэвтрүүлсэн. Бага тойрог шугамын үндсэн хамгаалалтыг найдваржуулах ажлыг богино хугацаанд тасралт саатал гаргалгүй амжилттай гүйцэтгэж чадсан. Шонхор дэд станц бага тойрог-110 сүлжээнд залгагдахад хамгийн том асуудал нь АШ-109, 110, 149, 150-ын үндсэн хамгаалалт оруулах асуудалтай байсныг 4 төгсгөлийн дагуу ялгаварт гүйдэлийн хамгаалалтыг оруулах санаачилга гарган ИХБ-4, Баруун, Үйлдвэр, Шонхор, Умард, Сэлбэ, Дорнод-2 дэд станцууд хооронд шилэн кабелийн сүлжээ бүхий дифференциал хамгаалалт оруулснаар эдгээр шугамууд хамгийн шилдэг шийдэлтэй үндсэн хамгаалалт орж чадсан. Мөн урд нь ашиглагдаж байсан өндөр хурдны логик хамгаалалт давхар орсоноор эдгээр 4 шугам 2 үндсэн хамгаалалтын системд орж, орчин үеийн реле хамгаалалт автоматикийн хамгийн ухаалаг шийдэл болсон юм.



220/110/35 кВ-ын Улаанбаатар дэд станцын АТ-2-ын 220/110 кВ-ын 6 ширхэг оруулга солих их засварын ажлыг гүйцэтгэсэн.

ПРП-110 дэд станцын өргөтгөлийн ажлын хүрээнд реле хамгаалалт автоматикийн байгууламжийн хоёрдогч хэлхээний гүйдэлийн хэлхээ, таслуурын таслах залгах хэлхээ, Т-2-ын үндсэн болон бэлтгэл хамгаалалтын хэлхээ, тоолуурын хэлхээ, удирдлагын хэлхээ, салгууруудын удирдлагын хэлхээний схем зураг боловсруулсан. Гадна 110 кВ-ын гүйдэлийн трансформаторын холболтын хайрцаг угсарч суурилуулсан. Гүйдэлийн трансформаторын хоёрдогч хэлхээний кабель татаж, гүйдэлийн трансформатор болон холболтын хайрцагт оруулж холболтуудыг хийсэн. 110 кВ-ын ЭТ-ын хоёрдогч хэлхээний кабель татаж холболтуудыг хийх, 110 кВ-ын салгуурын удирдлагын хайрцаг угсарч суурилуулсан. 110 кВ-ын шугамын салгуур болон секцийн салгуур хооронд кабель татаж холболтуудыг хийсэн. 0,4 кВ-ын тэжээлийн кабелиуд татаж холболтуудыг хийсэн. Шинэ тоноглолууд руу хоёрдогч хэлхээний кабель татагдах трассын дагуу шинээр лотки суурилуулсан. Т2 трансформаторын хамгаалалтын панель суурилуулж схем тулгалт хийн 110 кВ-ын ЭТ, Шу.С, С.С салгуурын холболт монтажийн ажил, Т2-ын 110 кВ-ын гүйдэлийн хэлхээ болон удирдлагын хоёрдогч хэлхээний холболт монтажийн ажил тус тус хийсэн.




◀ ЦАГ ҮЕИЙН АЖЛААР ▶



Ажилтнуудын дунд спортын тэмцээн уралдаан зохион байгуулах, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх зорилготой жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг боулинг, дартсын тэмцээнийг 2019 оны 12 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулж, тэмцээнд 7 багийн 85 ажилтан оролцож, шилдгүүдээ тодруулсан.

Улаанбаатар салбарын дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Ц.Хүрэлбаатар



ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын шалгалтын комисс 2020 оны ээлжит шалгалтын материалыг ажлын байрны онцлогт тохируулан чадамжид суурилсан хөтөлбөр, дүгнэх үзүүлэлтээр боловсруулж, 2019 оны 12 дугаар сард Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны төвийн хэсгийн 45 ажилтнаас ААД, ТАД-ийн ээлжит шалгалтыг авч ажилласан. Ээлжийн техникчээр дэвшин ажиллах 3 ажилтан, жинхлэн ажиллах 3 ажилтан, ажлын байр өөрчлөгдөх 1 ажилтан тус тус мэдлэгийн шалгалтаа амжилттай өгч, аюулгүй ажиллагааны эрхээ баталгаажуулсан.

2019 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс 2019 оны 12 дугаар 01-ний өдөр хүртэл хугацаанд зарлагдсан “Аюулгүй ажлын байр” аянд салбарын 14 нэгж хамрагдаж, нийт 114 зөрчил илрүүлснээс 85 зөрчилд эрсдлийг үнэлж 55 зөрчлийг бүрэн арилгаж ажилласан. Аяны хугацаанд 1 дүгээр байрыг 110 кВ-ын Хаалттай хуваариалх байгууламж, 2 дугаар байрыг Захиргаа, аж ахуйн алба, 3 дугаар байрыг Давхар дэд станцын хамт олон тус тус эзэлсэн.

- Ажилтнуудыг дасгал хөдөлгөөнд идэвхтэй хамруулах зорилгоор ширээний теннисний өрөөний хулдаасыг сольж, ширээг засварласан.
- Өдрийн хоолны цэсэнд эрүүл хүнсний бүтээгдэхүүн агуулсан хоолны нэр төрөл оруулж батлуулах, хоолны орцонд амтлагч, давсны хэрэглээг багасгах талаар технологийн картанд санал оруулах зэрэг судалгааны ажил хийгдэж байна.
- Конторын нийт 50 ажилтанд Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар, Ази фарм ХХК-аас томуу, томуу төст өвчин, 4-р үеийн вакцины талаар товч мэдээлэл, танилцуулга хийсэн.




“Эрүүл ажилтан бидний баялаг” зөвлөмжийн мөрөөр тус салбарын эрүүл мэндийн зөвлөлөөс 12 нэр төрлийн ажил гүйцэтгэх төлөвлөгөө гаргаж, дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:

- “Эрүүл, зохистой хооллолт” сэдвээр өдөрлөг зохион байгуулсан.
- “Сахарын өвчлөл, зөв хооллолт” сэдвээр конторын нийт 45 ажилтанд 1 цагийн сургалт явуулсан.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Засварын бригад 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдөр ХХБ-110, 220/110/35 кВ-ын Дархан дэд станцын тоноглолуудад үзлэг хийж, тосны түвшин, шаазан эд ангиудын цууралт, тоосжилт, халаагуурын ажиллагаа, КРУН, ОРУ-н гэрэлтүүлгийн ажиллагааг шалгасан. Мөн ВТ, ЭТ-уудыг даралт, тосон таслуурын тосны түвшинд үзлэг хийсэн.

110 кВ-ын Үйлдвэр А Б, 113, Сүхбаатар агаарын шугамын Т№ 1-28 хооронд, Баясгалант агаарын шугамын Т№ 49-320 хооронд, 114, 115-р агаарын шугамын нийт уртын дагуу ээлжит үзлэг, 110 кВ-ын Ерөө агаарын шугамын Т№ 180-302 -ын хооронд тасралтын зонд ээлжит бус үзлэг тус тус хийж, илэрсэн 110 кВ-ын Ерөө агаарын шугамын Т№ 212-н Сф-2ш, Т№ 233 Аф-1ш, 236 Сф -2ш, 244 Сф-2ш, 273 Вф-1ш нэвт цохигдсон элементийг гярландаар нь, 243 Аф-1ш, 268 Сф-1ш тус бүр хагарсан элементүүд сольж гэмтэл устгасан.



2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хооронд Сүхбаатар, Хөтөл, Шарын гол, Баруунхараа дэд станцуудад СКЭЧ ХХК-иар станцуудын барилга байгууламжийн геодезийн зураг төслийн ажлын хэмжилтүүдийг газар дээр нь хийлгэж, “СКЭЧ ХХК” станцуудын зураг боловсруулах ажлыг бүрэн хийж хүлээлгэн өгсөн.



ЦАГ ҮЕИЙН АЖЛААР



Реле хамгаалалт автоматик, хэмжилт, туршилтын алба салбарын аварга шалгаруулах спортын 5 төрөлт тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд 160 гаруй тамирчин ур чадвар, оюун ухаанаа сорин өрсөлдсөнөөс Сүхбаатар дэд станц, Зүүнхараа дэд станцын хамтарсан “Сэлэнгэ” баг тэргүүн байр эзэлж, шилжин явах цомын эзэн болсон. Тэмцээнд залуу тамирчид шинээр төрөн гарсан бөгөөд тэмцээний ганцаарчилсан төрлүүдэд баг тус бүрээс 2 тамирчин оролцуулан багийн төрлөөр явуулж, багийн онооны системээр дүгнэсэн нь онцлог болсон юм. Гар бөмбөгийн эмгэгтэй төрөлд “Шилдэг тамирчин”-аар Шарын гол дэд станцын ээлжийн техникч Э.Баярмаа сагсан бөмбөгийн эрэгтэй төрөлд “Шилдэг тамирчин”-аар шугамын засварын монтер С.Батмөнх нар тодорлоо.


Дархан-Уул аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс иргэдийн амар тайван амьдрах орчинг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд идэвх, санаачилгатай ажилласан Төвийн бүсийн салбарыг “Тэргүүний байгуулага”-аар өргөмжилсөн.

Салбарын 2019 оны шинэ жилийн арга хэмжээг Ашиглалт, шуурхай үйлчилгээний алба зохион байгуулсан ба арга хэмжээг угтаж ажилтнуудын дунд “Монита” хөгжөөнт тоглоом зохион байгуулж, нийт 40 эрэгтэй, 40 эмэгтэй ажилтан оролцсоноос “Супер монита”-аар дэд станцын засварын монтер Х.Батсүрэн, үйлчлэгч Л.Энхсайхан нар тодорч, Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны хамт олон БНХАУ-ын Манжуур хотод аялах эрхийн бичгээр шагнаж урамшуулсан. Мөн өвөрмөц бэлэг өгсөн монитагаар ХАБЭАИ Л.Мягмарбат, олон бэлэг өгсөн монитагаар сургалт бүтээмжийн инженер Н.Эрдэнэчимэг нар шалгарсан.

Арга хэмжээний үеэр “Найздаа тусалъя” сайн үйлсийн аян зохион байгуулж, Дархан-Уул аймгийн Дархан сумын 5-р баг Нарантолгойд оршин суугч 5 хүүхэдтэй иргэн Лхагвасүрэнгийн гэр бүлийг сонгон тусаллаа. Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны хамт олон байшингийн үүдний өргөтгөл хэсгийг засварлах, дулаалж гал тогооны өрөө болгох, ханын пийшинг нь засварлах, зуух хийх, Засварын албаны хамт олон хашааны том, жижиг хаалга хийх ажлуудыг гүйцэтгэж, бусад албаны хамт олон эд материалын дэмжлэг үзүүлж, нэг гэр бүлийг дулаан, тохитой өвөлжихөд тус дэм болсноороо 2020 оноо угтсан сайхан арга хэмжээ болсон юм.



Төвийн бүсийн салбарын компьютерийн инженер Н.Оюунболд



ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд 2019 оны 11, 12 дугаар сард нийт 17 ажилтанд ажлын байрны анхан шатны зааварчилгааг, 5 ажилтанд урьдчилсан зааварчилгааг, 2659 ажилтанд өдөр тутмын зааварчилгааг, 241 ажилтанд сар бүрийн ээлжит зааварчилгааг, ажил гүйцэтгэх бригадуудын нийт 225 ажилтанд тухайлсан зааварчилгааг өгч ажилласан.

Алба, хэсэг, дэд станцуудад аваар эсэргүүцэх дагал 8 удаа хийгдэж 91 ажилтан, ГЭД 6 удаа хийгдэж 84 ажилтан, ОЭД 4 удаа хийгдэж 62 ажилтан тус тус хамрагдсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг давхардсан тоогоор 69 удаа хийж 137 зөрчил, II шатны үзлэгийг 27 удаа хийж 74 зөрчил,

III шатны үзлэгийг 2 удаа хийж 13 зөрчлийг илрүүлж, устгах арга хэмжээг авч ажиллалаа.

Орхон сумын иргэн Батсайханы өвөлжөө, сууц нь шугамын хамгаалалтын бүсийн дэглэм зөрчсөн тул албан тоотыг Булган аймгийн Засаг даргад хүргүүлж ажилласан.

“Эрүүл ажилтан-Бидний баялаг” аяны хүрээнд Захиргаа, аж ахуйн албанаас 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр “Зөв хооллолтын өдөрлөг” зохион байгуулж, өглөөний цай, шинэ хайлмаг, каша, бүхэл үрийн гурилаар барьсан шинэ талх, шинэ ногооны салат, шар буурцгийн махтай цуйван зэрэг эрүүл, шим тэжээлтэй хоолоор ажилтнуудад үйлчилсэн.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Их болон урсгал засварын ажлаар Эрдэнэт дэд станцад ЭТ-204 шугамд WAMS, PMU төхөөрөмж суурилуулах, АТ-3 автотрансформаторт өндөр хүчдэлийн туршилт хийж, хоёрдогч хэлхээний ажиллагааг шалгах, Мөрөн дэд станцад Т-3 трансформаторт өндөр хүчдэлийн туршилт хийж, Булган дэд станцад Хутагийн шугамын реле хамгаалалт автоматикийн тавил өөрчлөх, Хархорин, Цэцэрлэг дэд станцад тоолуурын алдаа шалгаж баталгаажуулах ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн.

ТЗБАХ-ний ажлаар Мөрөн дэд станцад 2019 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Мөрөн 110 кВ-ын LB6-110GYW2 (100/5) маркийн гүйдэлийн трансформаторыг ТФЭМ-110Б-III-У1 (300/5) маркийн гүйдэлийн трансформатораар солих ажлыг гүйцэтгэсэн. Мөрөн дэд станцад DC-1 цэнэглэгч төхөөрөмжийг солих, Булган, Мөрөн, Арвайхээр дэд станцуудад шилэн кабель татаж интернэт холбох, Тосонцэнгэл дэд станцад 2 айлын сууцны ажлууд тус тус хийгдсэн.

Гэмтэл устгалтын ажлаар 220 кВ-ын ЭТ-203 ЦДАШ-ын №462, 463, 472 дугаар тулгууруудад ЧН тавих, тохируулах, №463 дугаар тулгуурын А,В,С фазын утсанд ороолт хийх, ЭТ-204 ЦДАШ-ын №442 дугаар тулгуурын В фазад элемент (2 дугаар үеэр элементийн пестик хугарсан) солих, 110 кВ-ын Цэцэрлэг ЦДАШ-ын №388 дугаар тулгуурыг тэгшлэх, №401 дүгээр тулгуурыг тэгшилж, 2 талд нь татуурга хийх, 110 кВ-ын Баянхонгор ЦДАШ-ын №423-424, 425 дугаар тулгууруудын II фазын утсанд судал тасарсан цэгт ороолт хийх, 110 кВ-ын Цэцэрлэг ЦДАШ-ын №966 дугаар тулгуурын III фазын утсанд ЧН-ийн угаар 9-10 судал тасарсан цэгт 50 метр оруулга хийж, I фазын утсанд ЧН тохируулж, 1 ширхэг ЧН нэмж тавих, Тосонцэнгэл дэд станцад Т-1 35 кВ-ын гүйдэлийн трансформаторыг сольж, трансформаторын дифференциал хамгаалалтыг ажилд оруулах, Булган дэд станцад шулуутгагч №2-ын модуль-1-ийг солих ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн.



Гэмтэл устгах ажил



Баянхонгор дэд станц Т-3



Мөрөн дэд станц Т-3



Эрдэнэт дэд станц АТ-3

Салбарын хэмжээнд шугам, тоноглолын найдвартай ажиллагааг хангах зорилгоор Эрдэнэт дэд станцад АТ-3 автотрансформаторт өндөр хүчдэлийн туршилт хийж, хоёрдогч хэлхээний ажиллагааг шалгах, Баянхонгор, Мөрөн дэд станцад 2.5 мВА чадлын Т-3 трансформаторыг суурилуулж, хоёрдогч хэлхээний холболт, трансформаторуудын 110 кВ талд ВМТ маркийн ТТ, 6 кВ талд 3 ячейка бүхий КРУН суурилуулж Т-3 трансформаторт өндөр хүчдэлийн туршилтын ажлыг тус тус гүйцэтгэсэн.

Эрдэнэт, Хишиг-Өндөр, Арвайхээр дэд станцын тостой тоноглолоос тосны сорьц авсан.

Дэлхийн банкны “Эрчим хүчний төсөл-2” хөтөлбөрийн хүрээнд 2019 оны 11 дүгээр сарын 14-20-ны өдрүүдэд Эрдэнэт дэд станцад 35 кВ-ын Дэнж багийн 2 хэлхээ шугамын холболтын тоноглолын өргөтгөлийн ажлыг Да хот ХХК гүйцэтгэсэн.


ЦАГ ҮЕИЙН АЖЛААР

Хангайн бүсийн салбар 2019 оны ажлаа дүгнэн шинэ жилийн арга хэмжээгээ зохион байгууллаа. Салбарын “Тэргүүний ажилтан”-аар Захиргаа, аж ахуйн албаны сантехникч М.Батсайхан, “Шилдэг залуу ажилтан”-аар Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны компьютерийн инженер Э.Батням нар тус тус шалгарсан.

Мөн салбарын шугамын засварын монтёр Х.Сундуй нь компанийн 2019 оны “Хөдөлмөрийн аварга засварын монтёр”-оор шалгарсан нь баяр дээр баяр нэмсэн сайхан үйл явдал боллоо.

Компанийнхаа хамт олонд 2020 ондоо ажил үйлс нь амжилт бүтээлээр дүүрэн, эрүүл энх, аз жаргалтай байхын өлзийтэй сайхан ерөөлийг өргөн дэвшүүлэе.

Хангайн бүсийн салбарын сургалт, бүтээмжийн инженер В.Адъяа



ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

2019 онд урьдчилсан зааварчилгаанд 35 ажилтан, сарын давтан зааварчилгаанд 1674 ажилтан, ээлжит бус зааварчилгаанд 1397 ажилтан, өдөр тутмын давтан зааварчилгаанд 26455 ажилтан давхардсан тоогоор хамрагдаж ажилласан.

Салбарын хэмжээнд аваар эсэргүүцэх дасгалыг 45 удаа зохион байгуулж 579 ажилтан, галын аюулаас урьдчилан сэргийлэх дасгал 42 удаа зохион байгуулж 624 ажилтан, анхны тусламж үзүүлэх дасгалыг 687 удаа зохион байгуулж 901 ажилтан хамрагдан аюул ослоос урьдчилан сэргийлж ажилласан.

Салбарын хэмжээнд дэд станцуудын цахилгаан тоног төхөөрөмжүүдэд болон ЦДАШ-уудад хийгдэх төлөвлөгөөт их ба урсгал засвар, гэмтэл устгалтын ажлаар аюулгүй ажиллагааны нарыаар 723 ажил, шийдвэрээр 403 ажил хийгдсэн.

Багануур, Хот, Төв дэд станцуудад гэнэтийн шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг албадын дарга нарт танилцуулж, зөрчил гаргасан ажилтнуудад хариуцлага тооцох үүрэг даалгавар өгч ажилласан.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

ТЗБАХ-ний ажлаар 2019 оны 11, 12 дугаар сард 207, 110 кВ-ын Чойр-Айраг, Айраг-Сайншанд, Сайншанд-Замын-Үүд цахилгаан дамжуулах агаарын шугамуудад үндсэн болон бэлтгэл хамгаалалт оруулах, заградитель, фильтр, конденсатор шинээр суурилуулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Урсгал засварын ажлаар Хот дэд станцын төв дохиоллын хэлхээ шинэчлэх, Бор-Өндөр дэд станцын Дархан 35 кВ, Өндөрхаан дэд станц Өлзийт 35 кВ тосон таслууруудыг вакуум таслуураар сольж, хамгаалалтыг микропроцессорны хамгаалалтаар солих, Сайншанд 110 кВ ШинС-ын газардуулгын хугарсан чөмөг сольж тохиргоо хийх, Айраг дэд станцад АЧР-н хэлхээний гэмтэл устгах, Багануур дэд станцад гаражийн гүйдэг хаалганы дугуй солих, Өндөрхаан дэд станцад Т-1 110 кВ ТТ-ын В фазын 2 ширхэг шатсан халаагуур, Өлзийт 35 кВ тосон таслуурын шатсан таслах ороомог солих зэрэг ажил хийж гүйцэтгэсэн.

Ашиглалтын түвшин дээшлүүлэх ажлаар УАЗ-2206 маркийн 93-63БРА дугаартай автомашинд үйлчилгээ хийх, реле хамгаалалт автоматикийн үзлэг үйлчилгээ, Айраг дэд станцад аккумуляторын батарейн үзлэг, 10 кВ ХХБ халаагуур солих, 6 кВ ХХБ-д гаргалгааны тоолуураас мэдээлэл авах, дэд станцын хашааны хаалганы цоож солих, Бор-Өндөр-Өндөрхаан 110 кВ-ын ЦДАШ-ын тулгуур №24 I фаз мултарч унасныг хэвийн болгох, Бор-Өндөр-Баянмөнх агаарын шугамд үзлэг хийх, II-р шатны үзлэгээр илэрсэн зөрчил устгах, Чойр дэд станцад Т-1 трансформаторын РПН-ны

логометрийн 220/12В бууруулагч трансформатор гэмтсэнийг солих, ОПУ-н дээрх гэрэлтүүлгийн 5 ширхэг шатсан гэрэл солих, ЗРУ-н дээврийн усны хаялага салсан байсныг 12 метр полсво төмрөөр даруулж бэхэлж тогтоох, Баянмөнх-Өндөрхаан 110 кВ агаарын шугамд үзлэг хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн.

Гэмтэл устгах ажлаар Багануур-Чойр 207-р цахилгаан дамжуулах агаарын шугамын болон LAND-100 маркийн 56-05 дугаартай автомашин, Prius 20 маркийн 19-98 УБЧ улсын дугаартай автомашинуудад гарсан гэмтлийг устгасан.



ЦАГ ҮЕИЙН АЖЛААР

Манай салбарын хувьд 2019 он амжилт бүтээл дүүрэн, ажил хөдөлмөрөө төр засгаараа үнэлүүлсэн, дурсамж дүүрэн жил болж өнгөрлөө. Салбарын сүлд модны наадам, шинэ жилийн баярын цэнгүүн 2019 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Багануур хотын "Наран" ресторонд болов. Цэнгүүнийг салбарын дарга Н.Мөнгөнхөлөгт нээж, 2019 онд гаргасан ололт амжилт, алдаа оноогоо дүгнэж шинэ ондоо илүү их амжилтаар дүүрэн байхын ерөөлийг өргөж, төрийн одон медаль, Эрчим хүчний яамны шагналаар шагнагдсан ажилтнуудаа баяр хүргэж, 2019 онд амжилтаараа хамт олноо хошуучилж, салбарын "Тэргүүний ажилтан"-аар шалгарсан Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны өндөр үзэлзлэлийн холбооны инженер Ц.Энхжаргалд аваргын тууз, өргөмжлөл, мөнгөн шагнал гардууллаа.



АШУА-ны дарга Б.Ганбаатар

Салбарын 2019 оны "Шилдэг хамт олон"-оор С.Бямбасүрэн даргатай Захиргаа, аж ахуйн алба, "Шилдэг ажлын байр"-аар Замын-Үүд дэд станцын хамт олон шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан. Багануур дүүргийн 2019 оны "Тэргүүний инженер техникийн ажилтан"-аар Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны дарга Б.Ганбаатар шалгарсан.



Чойр хэсгийн азтангууд

хэсэг, дэд станцуудын тэргүүний ажилтнуудаа шалгаруулан урамшуулж, азтануудаа тодруулсан. Ирж буй шинэ ондоо хамт олноороо ажлын өндөр амжилт бүтээлтэй, гэр бүлээрээ энх амгалан түвшин жаргалтай байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

Зүүн-Өмнөд бүсийн салбарын мэдээлэл технологийн инженер Б.Батням



Захиргаа аж ахуйн хамт олон



ГОВИЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд 2019 оны 11, 12 дугаар сард нарыдаар 28, шийдвэрээр 46 ажил хийгдсэн. Наряд шийдвэрээр ажил гүйцэтгэхэд ажлын аюулгүй байдлыг хариуцагчид болон бригадын бүрэлдэхүүнд онцгой анхаарч, шат шатны зааварчилгааг чанартай өгч, хяналт тавьж ажилласан.

Салбарын хэмжээнд 8 удаагийн дасгал зохион байгуулагдаж 70 ажилтан хамрагдсан, сарын давтан зааварчилгааг 129 ажилтанд, тухайлсан зааварчилгааг 580 ажилтанд, ээлжит бус зааварчилгааг 147 ажилтанд өгч ажилласан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг 558 удаа хийж 28 зөрчил, II шатны үзлэгийг 21 удаа хийж 32 зөрчил илрүүлэн устгаж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч ажилласан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг 25 удаа хийж 13 зөрчил илрүүлж, зөрчлийг устгах үүрэг даалгавар өгч ажилласан.

2019 оны 12 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд төв компани дээр зохион байгуулагдсан ХАБЭА, хяналтын инженерийн VI зөвлөгөөнд ХАБЭА-н инженер О.Дөлгөөн оролцож, салбарын 2019 оны ХАБЭА-н ажлын тайлангаа танилцуулж, санал хүсэлтээ илэрхийлсэн. Салбарын инженер техникийн болон шуурхай ажиллагааны ажилтнуудын уялдаа холбоог сайжруулах, ажилдаа хандах хандлагыг өөрчлөх зорилгоор инженер техникийн ажилтан болон шуурхай ажиллагааны ажилтнуудын дунд 16 цагийн сургалт, зөвлөгөөнийг 2019 оны 12 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтаар илтгэгч Бандихүү "Хувь хүний харилцаа болон байгууллагын соёл" сэдэвт илтгэл тавьсан. Нийт 48 ажилтан хамрагдсан. Реле хамгаалалт автоматикийн монтер Ц.Мөнхтөрийг Дархан-Уул аймгийн Технологийн сургуулиас зохион байгуулсан

"Эрчим хүчний системийн реле хамгаалалт" сэдэвт мэргэжил дээшлүүлэх, Тавантолгой дэд станцын ээлжийн монтер Б.Цэндпүрэв, Мандалговь дэд станцын ээлжийн монтер Ж.Занданхорол нарыг компанийн сургалтын төвийн "Хуваарилах байгууламж дэд станцын ээлжийн монтер"-ын чадамжийн гэрчилгээ олгох, ашиглалтын инженер Б.Бүрэннэмэх, горим тооцооны инженер М.Сувд нарыг худалдан авах ажиллагааны "АЗ сертификат олгох", хэмжүүр тоолуурын инженер Х.Дашнямыг ШУТИС-аас зохион байгуулсан "Эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх" сургалтад тус тус хамруулсан.

ДСУМС программын ашиглалтыг сайжруулах зорилгоор сургалт зохион байгуулж, ажилтнуудын ДСУМС программ дээр ажиллахад эргэлзээтэй байсан, мэдэхгүй байсан зүйлүүдийг ойлгуулж чадсан ач холбогдолтой сургалт болсон.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Оффисын шинэ байр ашиглалтад орсонтой холбоотойгоор гадна чиглэлийн 5, дотор чиглэлийн 3 хяналтын камер, бичигч, дэлгэц суурилуулж, гадна талбай болон автограж, үүдний хэсгүүдийг бүрэн хянах боломжтой болсон. 220/110/35 кВ-ын Мандал дэд станц ашиглалтад орсоноор шуурхай ажиллагаа явуулахад интернэт зайлшгүй шаардлагатай болж Оффис-Мандалговь-Мандал гэсэн цэгээс цэгт (point to point) холболтоор интернэт холболтыг шийдсэн бөгөөд тус холболтыг ашиглан гражид суурилуулсан камеруудыг харуул хамгаалалтын ажилтны байранд хянаж байна.




110/35/10 кВ-ын Даланзадгад дэд станцын 35 кВ-ын ИХБ нь Даланзадгад ДЦС-ын ус хөргөх байгууламжийн салхин доор нь байрладаг учраас 35 кВ-ын ИХБ-ийн тоноглолуудын хөндийрүүлгийг муутгаж, хөндийрүүлэгч нэвт цохигдох, хүйтний улиралд тасралт гарах нөхцөл үүсч байсан. Иймд 35 кВ-ын Далан А, Б АШ-ын порталыг ашиглан салхи нэвтэрдэг зориулалтын торон хашаагаар 35 кВ-ын ИХБ-ийн тоноглолуудад уурын хаалт барьж угсрах ажлыг хийж гүйцэтгэсэн.

225-р АШ-ын урсгал засварын ажлыг 2019 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Говийн бүсийн болон Зүүн-Өмнөд бүсийн салбарын 24 ажилтны бүрэлдэхүүнтэй 4 бригад нийт 85 тулгуурт 145 ширхэг элементийг солих ажлыг хийж гүйцэтгэсэн.



2019 оны 12 дугаар сарын 29-30-ны өдрийн хооронд 220/110/35/10 кВ-ын Тавантолгой дэд станцын 110 кВ-ын Тавантолгой-Даланзадгад агаарын шугамын үндсэн хамгаалалтын ВЧ постны фидерийн холболтын кабель гэмтэлтэй байсныг гэмтлийг нь ахиулж холболт хийн хэвийн болгосон.



ЦАГ ҮЕИЙН АЖЛААР


Салбарын 2019-2020 оны шинэ жилийн цэнгүүнийг 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Дундговь аймгийн төв Мандалговь хотноо зохион байгуулж, 2019 оны тэргүүний болон шилдэг ажилтнуудаа шалгарууллаа. Жилийн хугацаанд үндсэн үүрэгт ажлаа чанартай гүйцэтгэн цаг ашиглалтын болон ХАБЭА-н зөрчилгүй, хамт олноо хошуучлан ажилласан Санхүү, эдийн засгийн албаны тооцооны нягтлан бодогч Т.Оюунбилэг салбарын "Тэргүүний ажилтан"-аар шалгарч, Өмнөговь аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр Даланзадгад дэд станцын ээлжийн монтер Г.Энхболд, У.Бат-Учрал, мөнгөн шагналаар Мандалговь дэд станцын ээлжийн инженер Г.Содномцэрэн, засварын монтер П.Отгонтөгс, Засварын албаны дарга Ж.Шарав, автын механик Б.Түвдэндорж, засварын монтер Э.Алтанширээ, А.Дорждэрэм, хэмжилт



Тус салбарын шинэ оффисын байр ашиглалтад орсонтой холбоотойгоор дэд станцууд болон албадын дунд "Ажлын байрны тохижилтыг сайжруулж, ажлын байрны соёл-5С-г хэрэгжүүлж" сэдэвт уралдаан зарлан, ажилтнуудын идэвх санаачилга, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж ажилласнаар уралдааны 1 дүгээр байранд Захиргаа аж ахуйн алба, 2 дугаар байранд Ашиглалт, шуурхай үйлчилгээний алба, "Ажлын байрны соёл-5С"-г хэрэгжүүлэн хэвшүүлж ажилласан дэд станцаар Тавантолгой дэд станц тус тус шалгарсан.

Говийн бүсийн салбарын бичиг хэрэг, архивч Б.Мөнхцэцэг





ЗАСВАРЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭВ

220/110/35/6 кВ-ын Эрдэнэт дэд станцын гэмтэж, ашиглалтаас гарсан 200 МВА чадалтай OSFPSZ9-200000/230 маркийн автотрансформатор-2-ын гэмтлийг устгах их засварын ажлыг Украин улсын “ЗТЗ” компанийн мэргэжилтнүүдийн удирдлага дор Төсөл хөтөлбөрийн хэлтэс, Техник бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Хангай бүсийн

салбарын инженер техникийн ажилтнууд 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хооронд Трансформаторын засварын цехэд амжилттай хийж гүйцэтгэлээ. Засварын ажлын бэлтгэл болон үндсэн ажлын хүрээнд хийгдсэн гол ажлуудыг тоймлон танилцуулж байна. Үүнд:

Бэлтгэл ажлын хүрээнд

- Гэмтэл устгах засварын ажлын нэгдсэн төлөвлөгөө боловсруулах болон засварын ажилд шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материалын нэр төрөл, тоо ширхэгийг тодорхойлох ажлыг “ЗТЗ” компанитай хамтран хийж гүйцэтгэсэн.
- Засварын ажилд шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материалыг БНХАУ-ын “Shanghai Huaming Power Equipment”,

Швейцар улсын “Weidmann”, Украин улсын “ZTZ” компани, Чех улсын “Diram” компаниудад захиалж авсан.

Засварын ажлын хүрээнд

- Автотрансформатор 2-ын идэвхт хэсгийг сугалж, зүрхэвч, даравчийн суларсан боолт, контактуудыг чангалах, гэмтэлтэй ороодосын үзүүрүүдийг хаягжуулан тайлах, цэвэрлэх, хуучирч муудсан изоляцыг хусах, нэвт цохигдсон хөндлөвч цаас, моднуудыг тайлж авах, үндсэн бакны шалыг цэвэрлэх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн.
- Гэмтэж урагдсан тусгаарлагч цааснууд, бэхэлгээний зориулалттай шахмал кардон бүхий хөндлөвч модуудыг сольсон.
- Гэмтсэн 220 кВ-ын С фазын нум унтраах хэсгийг шинээр сольж, суурилуулах, 220 кВ-ын В фазын контактийн хэсгийг сольж гэмтлийг засварлах, А,В,С 3 фазын РПН-ын тохируулга, туршилтийг хийсэн.
- 220/110/35 кВ-ын ороомгийн гаргалгааны хэсэг дээрх гэмтсэн изоляцийг хөндийрүүлэгч цаас болон киперний лентээр ороож сэргээн засварласан.
- Трансформаторын идэвхт хэсгийн баруун, зүүн талаар бороожуулагч системийг угсарч, хатаалтын явцад хяналт тавих 7 төрлийн өгөгдөлд хэмжилт хийх дохиоллын үзүүрийг бэлтгэж, холболт хийсэн. Бороожуулагчийн аргаар трансформаторыг угаах хатаах ажилд МТ-100 маркийн насос, вакуум насос, ПХБ төслийн DMU 50.2000 24С тос цэвэрлэх төхөөрөмжийг ашигласан бөгөөд хатаалтын ажлыг 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 2019 оны

12 дугаар сарын 23-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн.

- Хатаалтын ажлыг гүйцэтгэхдээ өдрийн 24 цагийн 12 цагт тосыг 900 хүртэл халааж, бороожуулагчийн схемээр угаах, хатаах 12 цагт вакуумдаж усыг авах үйл ажиллагааны зарчмыг баримтлан 14 удаагийн циклээр хатаалтын ажлыг гүйцэтгэсэн.
- Трансформаторын хатаалтын явц, үр дүнд дүгнэлт хийх доорх 6 төрлийн шинжилгээг Химийн лабораторид өдөр тутам хийсэн. Үүнд:
 1. Тосны хийн хроматограф - 8 удаа
 2. Хатуу материалын чийгийг тодорхойлох - 4 удаа
 3. Тосны цахилгаан даац - 23 удаа
 4. Тосон дахь усны агуулгыг тодорхойлох - 15 удаа
 5. Тосны хүчлийн тоо тодорхойлох - 15 удаа
 6. Тосны тангенс дельта тодорхойлох - 23 удаа
- Автотрансформаторын хатаалтын ажил дууссаны дараа автотрансформаторт хийх 50 тн тосыг ПХБ төслийн тоног төхөөрөмжөөр цэвэрлэн, хоргүйжүүлсэн.
- Хатаалтын ажлын явцад автотрансформаторт хийсэн өндөр хүчдэлийн туршилтийн хэмжилтийн утга болон тосны шинжилгээний үр дүнд үндэслэн засварын ажлыг дуусгавар болгож тээвэрлэхэд бэлэн болгож ажилласан.

Төсөл хөтөлбөрийн хэлтсийн
ахлах бөгөөд төсөл хөтөлбөрийн инженер
Т.Цэвэгсүрэн



2019 ОНЫ “ШИЛДЭГ ДЭД СТАНЦ”-ЫГ ШАЛГАРУУЛАВ

Компанийн хэмжээнд “Ажлын байрны соёл-5С” хөтөлбөрийг жилийн турш амжилттай хэрэгжүүлсэн 2019 оны “Шилдэг дэд станц”-аар 1 дүгээр байрт Хангайн бүсийн салбарын Мөрөн дэд станц, 2 дугаар байрт Улаанбаатар салбарын Баянчандмань дэд станц, 3 дугаар байрт Төвийн бүсийн салбарын Хөтөл дэд станц тус тус шалгарав.

“Ажлын байрны соёл-5С” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, компанийн 2019 оны “Шилдэг дэд станц”-аар шалгарсан Мөрөн, Баянчандмань, Хөтөл дэд станцын хамт олонд баяр хүргэж, ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.

Сургалт бүтээмжийн
хэлтсийн сургалт, бүтээмжийн инженер
Л.Энхжаргал



1 дүгээр байрт шалгарсан Хангайн бүсийн салбарын
Мөрөн дэд станцын хамт олон



2 дугаар байрт шалгарсан Улаанбаатар салбарын
Баянчандмань дэд станцын хамт олон



3-р байрт шалгарсан Төвийн бүсийн салбарын
Хөтөл дэд станцын хамт олон



СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ

ЧАДАМЖИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОВ

Компанийн Зүүн-Өмнөд бүсийн салбарын сургалтын төвд “Хуваарилах байгууламж дэд станцын ээлжийн монёрын чадамжийн гэрчилгээний эрх олгох” сургалт 2019 оны 11 дүгээр сарын 11-20-ны өдрүүдэд, “Хуваарилах байгууламж дэд станцын тоноглол ашиглалт засварын монёрын чадамжийн гэрчилгээний эрх олгох” сургалт 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 07-ны өдрүүдэд тус тус зохион байгуулагдаж, нийт 37 ажилтан хамрагдсан.

Сургалт бүтээмжийн хэлтсийн сургалт, бүтээмжийн мэргэжилтэн Л.Энхжаргал



ГАДААД СУРГАЛТ

Диспетчерийн үндэсний төв ХХК-аас БНХАУ-ын Нанжин хотод АBB компани болон Нанжин электрик групптэй хамтран 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсан “Ухаалаг эрчим хүч”-ний чиглэлийн сургалт семинарт компанийн Улаанбаатар салбарын реле хамгаалалт автоматикийн инженер Б.Мөнхбадрал, Зүүн-Өмнөд бүсийн салбарын Сайншанд дэд станцын реле хамгаалалт автоматикийн инженер М.Төрмандах нарыг хамруулсан.

Сургалтын үеэр Нанжин электрик групп болон АBB SAC үйлдвэрийн удирдлагууд сургалт семинарт оролцогчдыг хүлээн авч, үйлдвэрийн үйл ажиллагаа, Хятадын эрчим хүчний чиг хандлага, өнөөгийн байдал, ирээдүйн хөгжил, шинэ дэвшилтэт техник технологи, шийдлүүдийн талаар танилцуулга хийсэн бөгөөд сургалт семинар хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгуулагдлаа.

Сургалт бүтээмжийн хэлтсийн сургалт, бүтээмжийн инженер Л.Энхжаргал



ЛЕКЦ УНШЛАА



Компанийн зүгээс ажилтнуудынхаа хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдөр “Авлигын хор хөнөөл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” сэдвээр сургалт зохион байгуулав.

Сургалтад Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан комиссар Б.Тэрбиш лекц уншлаа.


Сургалт бүтээмжийн хэлтсийн сургалт, бүтээмжийн инженер Л.Энхжаргал

ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАВ

Компанийн худалдан авах ажиллагаа, хангамжийн ажилтнуудын ээлжит зөвлөгөөнийг 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Улаанбаатар хотноо Төв удирдлага дээр зохион байгуулсан.

Зөвлөгөөнөөр компанийн 2019 оны худалдан авах төлөвлөгөөний тайлангийн хэрэгжилт, гүйцэтгэлийг дүгнэн ярилцаж, 2020 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, ТЗБАХ, хөрөнгө оруулалт, их болон урсгал засварын ажлууд дээр нарийвчлан ярилцаж, төсөв, нэршил, багцлалууд дээр нэгдсэн ойлголтод хүрч, санал солилцлоо. Жил бүр зохион байгуулагддаг энэхүү зөвлөгөөн нь өнгөрсөн онд хийсэн ажлаа дүгнэн, тулгамдаж байгаа асуудлуудаа зөвшилцөн нэгтгэж, ирэх ондоо ажлаа хэрхэн чанартай, хурдан хугацаанд зохион байгуулахад санал солилцсон ач холбогдолтой, үр дүнтэй болдгоороо онцлогтой байдаг.

Худалдан авах ажиллагаа, ханган нийлүүлэлтийн хэлтсийн дарга Ц.Батбаяр



ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАВ

Компанийн реле хамгаалалт автоматикийн инженер техникийн ажилтнуудын ээлжит зөвлөгөөнийг 2019 оны 12 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо төв компани дээр зохион байгуулж, зөвлөгөөнд нийт 52 инженер техникийн ажилтан оролцсон.

Зөвлөгөөнөөр компанийн 2019-2020 оны өвлийн бэлтгэл ажил хэрхэн хангагдсан болон компанийн хэмжээнд хийгдсэн ТЗБАХ, хөрөнгө оруулалт, их болон урсгал засварын ажлын

тайлан, гүйцэтгэлийн талаар хэлэлцэж, техникийн хяналтын сайжруулалт, шинээр нэвтэрч байгаа микропроцессорын баазын реле хамгаалалт автоматикийн төхөөрөмжүүдийн ашиглалт, үзлэг үйлчилгээг хэрхэн хийх, тэдгээрийн онолын ухагдахууны онцлогууд, шинээр нэвтэрч байгаа багаж төхөөрөмжүүдээр хэмжих аргачлалын талаар сургалт хийж, харилцан мэдээлэл солилцсон юм.

Реле хамгаалалт автоматикийн инженер техникийн ажилтнуудын

ээлжит зөвлөгөөн сүүлийн 3 жил зохион байгуулагдаагүй тасарсан ба энэ жилд зохион байгуулагдсан нь мэдлэг, мэдээллээ солилцсон, тулгамдаж байгаа асуудлуудаа зөвшилцөн нэгтгэсэн, ололт амжилтаа хэлэлцсэн, онцгойлон шийдвэрлүүлэх ажлын санал гаргасан ач холбогдолтой, үр дүнтэй зөвлөгөөн болсон.

Реле хамгаалалт автоматик, хэмжилт, туршилтын албаны дарга Н.Батбаяр



ХАБЭА, ХЯНАЛТЫН ИНЖЕНЕРИЙН VI ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАВ

Компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, хяналтын инженерүүдийн VI зөвлөгөөн 2019 оны 12 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулагдав. Зөвлөгөөнд ХАБЭА, хяналтын 19 инженер техникийн ажилтан оролцож, компанийн 2018-2019 оны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон техник хяналтын ажлын тайланг салбар бүрээр танилцуулж, 2018 зөвлөгөөнөөс гаргасан шийдвэрийн биелэлтийг хэлэлцэж, 2020 оныг “Эерэг хандлага-Эрүүл орчин” уриан дор ажиллах жил болгон зарлаж, зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг компанийн удирдлагуудад тогтмол танилцуулж байхаар шийдвэрлэв.

Мөн зөвлөгөөнөөс 2020 оны VII дугаар зөвлөгөөнийг Хангайн бүсийн салбарт зохион байгуулахаар шилжин явах цомыг гардууллаа.


Хяналт мониторингийн хэлтсийн дарга Я.Мөнхтөр

ТӨРИЙН ШАГНАЛ ХҮРТЭВ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын эстрада жааз хөгжмийн 50 жилийн түүхэнд, онцгой гавьяа байгуулсан улсын филармонийн Баянмонгол чуулгын үе үеийн уран бүтээлчдийн бүтээл туурвил, хөдөлмөр зүтгэлийг үнэлж, тус чуулгын төлөөлөл болох тухайн үед дууны инженерээр ажиллаж байсан манай компанийн ахмад настан Дондойн Гантөмөр төрийн шагнал хүртсэнд баяр хүргэж, эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Т.Аюуш





ШИНЭ ЖИЛИЙН БАЯРЫН ЦЭНГҮҮН



ЭХТА тэмдгээр шагнагдсан СЭЗХ-ийн ахлах эдийн засагч
Б.Ганцэцэг удирдлагуудын хамт

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК улирч буй 2019 оноо үдэж, ирж буй 2020 оноо угтах шинэ жилийн цэнгүүнээ 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж, компанийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу мэндчилгээ дэвшүүлж, баярын цэнгүүнийг нээлээ. Цэнгүүний үеэр 2019 онд ажил үйлсээрээ шалгарч, амжилт гарган хамт олноо хошуучлан ажилласан компанийн "Хөдөлмөрийн аварга"-ууд, Төв удирдлагын "Тэргүүний ажилтан"-аа тодруулж, аваргын тууз, өргөмжлөлийг ёслол төгөлдөр гардуулан баяр хүргэж, хүндэтгэл үзүүлэв.

Мөн "Эрчим хүчний тэргүүний ажилтан" тэмдгээр Санхүү, эдийн засгийн хэлтсийн ахлах эдийн засагч Б.Ганцэцэг, Улаанбаатар салбарын мэдээлэл технологийн инженер Э.Бүрэнжаргал, радио холбооны инженер А.Гүнбарс, Зүүн-Өмнөд бүсийн салбарын Хот дэд станцын ээлжийн техникч Н.Урантогос, Эрчим хүчний зохицуулах хорооны "Хүндэт тэмдэг"-ээр Хяналт мониторингийн хэлтсийн дарга Я.Мөнхтөр, Эрчим хүчний зохицуулах хорооны "Хүндэт жуух бичиг"-ээр Техникийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах бөгөөд ашиглалтын инженер Б.Энхбат нар шагнагдсаныг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Насантогтох, Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч Э.Түвшинчулуун, компанийн удирдлагууд гардуулж, баяр хүргэсэн юм.

Компанийн Төв удирдлагын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос Монголын залуучуудын холбооны "Тэргүүний залуу" тэмдгээр Техникийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн техникийн нөхцөл хариуцсан инженер Б.Пүрэвхүү, Шуурхай зохицуулалтын хэлтсийн диспетчер инженер Ч.Бат-Эрдэнэ, "Хөдөлмөрийн алдар" тэмдгээр Төсөл хөтөлбөрийн хэлтсийн засварын монтер Б.Дүнбэн-Ойдов, ПХБ-ийн төслийн монтер Б.Сэргэлэнбаяр нарыг шагнаж, баяр хүргэлээ.

Цэнгүүний арга хэмжээнд өвлийн өвгөн аав цасан охидын хамт хүрэлцэн ирж мэндчилгээ дэвшүүлж, 2019 онд амжилт бүтээл дүүрэн ажилласан ажилтнуудыг өвлийн өвгөний бэлгээр шагнаж урамшууллаа. Мөн шинэ жилийн цэнгүүний үеэр ажилтнуудын дунд азын сугалаа зохион байгуулж, Шуурхай зохицуулалтын хэлтсийн диспетчер инженер Х.Лхагвасүрэн "Супер азтан" болов.

Цаг хугацааны түүх болон үлдэж буй хуучин оноо амжилт бүтээлээр үдэж, угтан ирж буй шинэ оноо хийж бүтээх урам зоригор угтаж байгаа хамт олон та бүхэндээ ажлын өндөр амжилт, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Захиргаа удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн Т.Аюуш



ЭХТА тэмдгээр шагнагдсан Зүүн-Өмнөд бүсийн салбарын Хот дэд станцын ээлжийн техникч Н.Урантогос



ЭХТА тэмдгээр шагнагдсан УБС-ын мэдээлэл технологийн инженер Э.Бүрэнжаргал



"Супер азтан" ШЗХ-ийн диспетчер инженер Х.Лхагвасүрэн



АЛТАН МЕДАЛИЙН ЭЗЭН БОЛЛОО

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл доор түргэн болон түргэвчилсэн тоглолтын улсын аварга шалгаруулах шатрын тэмцээн 2019 оны 11 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд Төрийн ордны ёслол хүндэтгэлийн өргөөнд амжилттай зохион байгуулагдаж, манай компанийн Мэдээллийн технологийн хэлтсийн программист инженер Б.Баярмаа түргэвчилсэн тоглолтын /Рапид/ эмэгтэй ангилалд нэгдүгээр байр эзэлж, алтан медалийн эзэн боллоо.



Захиргаа удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн Т.Аюуш



100 БУУДАЛТ ДААМНЫ ТЭМЦЭЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦОВ

Эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын ахмадуудын дунд зуун буудалт даамны тэмцээн 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр ДЦС-3 ТӨХК-ийн Соёл хүмүүжлийн төвд зохион байгуулагдаж, олон улсын даамны холбооны албан ёсны лицензтэй программаар олон улсын их мастер, Зуун буудалт даамны холбооны нарийн бичгийн дарга Г.Ганжаргал шүүн явуулсан юм.

Тэмцээнд 7 байгууллагын 15 ахмад тамирчин оролцож, оюун ухаанаа сорин өрсөлдсөнөөс Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн ахмад настан Б.Уртнасан эмэгтэй төрлийн 2 дугаар байрт шалгарч, мөнгөн медаль хүртэв.

Захиргаа удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн Т.Аюуш